



УЛААНБААТАР

хотын Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх Захиргааны ТОГТООЛ

1967 оны 6-р сарын 2-ны өдөр

Дугаар 165.

Улаанбаатар хот

13-ийн 1990-ийн 140-р тогтоолоор хүчингүй.

КИНО ТАНХИМУУД БАЙГУУЛАХ ТУХАЙ.

Нийслэлийн захын районуудад оршин суугч байгаа хөдөлмөрчдийг киногоор үйлчлэх аалыг хүртээмжтэй болгон сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх захиргаангаас ТОГТООХ нь:

1. Сүхбаатарын районы ОСГ-ийн 17,20-р хороо, Октябрийн районы ОСГ-ийн 6-р хороо, худалдаа бэлтгэлийн яамны төв бараа бааз, барилгын материалын яамны Тоосгоны 2-р завод, улсын тээврийн хорооны засвар үйлчилгээний станц, сүрьеэтэй хүүхдийг эмчлэх больницын улаанбулангуудыг кино танхим болгон байгуулах 1967 оны 5-р сарын 1-нээс эхлэн тогтмол үйлчилгээгээр хангах амжилуулахыг хотын соёлын хэлтэс /н.ЦЭНДЭЭЖЭЭ/-д даалгасугай.

2. Хотын нүүдлийн киноны газар /н.САНДҮЙ/-д ДААЛГАХ нь:

а/Шинээр байгуулагдсан кино танхимуудыг кино аппарат хэрэгсэл, кино зургаар хангах үзвэр үйлчилгээг тогтмол явуулж байсугай.

б/Кино үйлчилгээг баянга явуулахад ашигдуулсан тоосгоны 2-р завод төв бараа бааз, засвар үйлчилгээний станцын дэрэгдэх кино танхимын үйлчилгээ, болон бусад зардалд нь зориулан киноны орлогоос нь 10%-иар бодож шимтгэл төлж байсугай.

3. Кино танхимаар хөдөлмөрчдийг тогтмол үйлчлэх үзвэр үйлчилгээний жил улирал, сарын төлөвлөгөөг жигд биелүүлэх арга хэмжээ авахыг кино танхим бүхий албан байгууллагуудын дарга нарт даалгасугай.

4.Шинээр байгуулагдсан кино танхимуудын 1967 оны
орлогын төлөвлөгөө, орон тоог баглан өгсхийг хотын төлөв-
жаргээний комиссо /н.ШЕРНИН/-, Хөдөлмөр цалин хэлсний товчоо
/н.СЭДБААЗАР/-нарт даалгасугай.

5.Кино танхимуудын эжирхгатаанд хяналт төлбөж тодорхой
удирдлагаар хангаж ажиллахыг районүүдийн АДХ-ын Гүйцэтгэх
Захиргааны дарга нарт үүрэг болгосугай.



УЛААНБАТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ДАРГА
ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БҮНГИЙН ДАРГА

[Handwritten signature]

ЦЭДЭВ

[Handwritten signature]

ДАМДИНСҮРЭН

Нийлгэв

[Handwritten signature]

15%-Д-А.813487.